



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/306

Булган сум

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн төсөв, Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Соёлын төвийн барилгын их засвар (Орхон сум)”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Гурван уулын хишиг” ХХК-тай 524,000,000 (таван зуун хорин дөрвөн сая) төгрөгөөр гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Гурван уулын хишиг” ХХК-ийн захирал (Д.Мягмардорж)-д үүрэг болгосугай.

3. Ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 450,000,000 (дөрвөн зуун тавин сая), Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас 83,067,570 (наян гурван сая жаран долоон мянга таван зуун дал) төгрөгөөр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

4. Хөрөнгийг данс бүртгэлд тусгаж ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Орхон сумын Засаг дарга (Н.Амартүвшин)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ



Сугар Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010519

Аймгийн Засаг даргын 2024 оны  
05 дугаар сарын 30 ны/ний өдрийн А/326 дугаар  
захирамжийн хавсралт

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
3	Магадлашгүй ажил	7 557 235	Ү.Бямбасүрэн
4	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	3 778 618	Ү.Бямбасүрэн
5	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	16 000 000	Ү.Бямбасүрэн
6	Нормчлолын сан	680 151	Ү.Бямбасүрэн
7	Захиалагчийн техник хяналтын зардал	7 557 235	Ү.Бямбасүрэн
8	Ажлыг хийж гүйцэтгэх хугацаа	хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн